



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/258

Мандалговь

Г Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 16 дугаар зүйлийн 16.2.2 дэх заалт, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2018 оны 4 дүгээр сарын 27-ний, 2018 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар олгож, сунгасугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5203:2002, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015, Ахуйн шавьж мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт, үйлчилгээ MNS5161-3:2002 өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлэг, эмийн сангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох комисс (А.Нарантуяа)-д, Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших)-т тус тус даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

О. БАТ ЭРДЭНЭ

0200755

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 12-ны
 өдрийн *10.58* тоот захирамжийн хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
 ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
 НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хугацаа
1	"Ижий бараат хайрхан" ХХК	"Гэрэлт инээмсэглэл" шүдний эмнэлэг	Нүүр амны өвчний оношлогоо, эмчилгээ, хиймэл шүд хийх	ЭХ-15/10/1020	3 жил	2018-04-10 2021-04-10
2	"Абрай-Үр" ХХК	"Ар-Үр" эмийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1018	3 жил	2018-04-10 2021-04-10
3	"Галтай хайрхан" ХХК	"Төгс дэлгэц" эмнэлэг	Хэт авиа оношлогоо	ЭСХ-14/02/973	3 жил	2017-02-25 2020-02-25
4	"Наранбулаг" ХХК	"Наран булаг" халдваргүйжүүлэх үйлчилгээ	Ахуй шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ	АҮХ-15/10/1021	3 жил	2018-06-03 2021-06-03
5	"Угтаал далай" ХХК	"Угтаал далай" эмийн сан	Эм, гоо сайхны барааны жижиглэн худалдаа	ЭСХ-15/10/1035	2 жил	2017-12-09 2020-12-09
6	"Жас-Од" ХХК	"Шинэ-Од" шүдний эмнэлэг	Нүүр амны өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ-15/10/1026	3 жил	2018-07-09 2021-07-09
7	"Оточкой" ХХК	"Оточкой" эмнэлэг	Хүүхдийн өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ-15/10/1025	3 жил	2018-07-09 2021-07-09